

“Ховдын толь” сонин болон “Вестник Горно – Алтайска” сонины хамтын ажиллагааны хүрээнд



Алтайн бүгд найрамдах улсад “цасны барс” нэртэй их наадам болов. Тавдугаар сарын хоёр дахь арав хоногийн төгсгөлтэй зэрэгцэн өндөрлөж буй энэхүү арга хэмжээнд хөрш Монгол улсаас хүүхдүүд ирж оролцож байгаа бөгөөд нэг талаараа олон улсын чанартай үйл явдал болсон тухай сэтгүүлч Любовь Ивашкинагийн сурвалжилсныг орчуулан хүргэж байна.

Хилийн бүсэд орших Кош-Агачийн районд чуулсан оролцогч хүүхдүүд үнэнхүү сэтгэлээсээ цасны барсыг хайрлан хамгаалах үйлсэд нэгдэж байгаа нь бахархалтай санагдана. Тэрээр районы тов дэх ахмадын клубт таван жил дараалан зохиогдож ирсэн богоод жилээс жилд улам хогжүүн сайхан болж байгаа нь улам ч таатай юм.

“Амар тайван бvс нутаг” буюу /Зона покоя Укок/ нэрт байгаль, газарзvйн хvрээлэн болон Алтайн бvсийн тогтвортой хогжлийн сангаас анх санаачилж, 2010 онд АБНУ-ын хилийн районд энэ вйл ажиллагааг эхлvүлж байв. Дэлхийн байгаль хамгаалах сангийн Алтай - Саяны салбараас энэ санаачлагыг уухайлан дэмжиснээр АБНУ-д экологийн сэдэвт уралдаант шалгаруулалт, цаст уулнаа эзэн суугч ирбис гэрийн муураас эхлээд зэрлэг араатны амьдрах нохцлийг хамгаалахтай холбоотой сургалт гэгээрлийн вйл ажиллагаа давхар явагдсаар одоо доров дэх жилийг vзэж байна.

Нэгэнт хэвшил болж олон тvмнээр мэддэг болсон энэ вйл ажиллагааны таван жилийн ойг тохиолдуулан



“Сайлюгемск”-ийн vндэсний хvрээлэн /парк/ -аас дээрх байгууллага газруудтай нэгдэн идэвхтэй вйл ажиллагаа явуулж эхэлснээр барахгvй, Аргут голын хондийгоор товтэй Алтайн зэрлэг амьтад, цасны ирвэс болон аргаль хонь зэргийн нутагших орчин дахь хамгаалалтын бvсийг бий болгохоор болов.

Их наадмын нээлтэн дээр Дэлхийн унаган байгалийг хамгаалах сангийн Алтай – Саяны салбарын тослийн зохицуулагч Елена Репутанова энэхvв наадмыг “Оодрог зан толов хийгээд энэрэх сэтгэлийн баяр” гэж нэрлэмээр байгаагаа хэлсэн.

Мон районы депутатуудын зовлолийн дарга Сергей Майхиев энэхvв баярт оролцогч хvүхдvүдийн хvрээлэл улам оргожиж байгаад баяртай байна хэмээгээд, уламжлал болгоод буй ажлууд маань улаан номонд орсон ховор амьтдыг хамгаалахад дорвитой хувь нэмрээ оруулах, бvс нутгийн экологийн аялал жуулчлалыг хогжvүлэх, цасны ирвэс болон бусад зэрлэг амьтдын нутагшин амьдрах таатай орчинг нь хамгаалан бэхжvүлэх чухал хошvүрэг, Алтайн бvс нутгийн нэрийн хуудас болохуйц вйл хэрэг байгаасай гэж хvсэж байгаагаа илэрхийлсэн. Бид цасны барсыг хамгааллаа. Энэ вйл хэрэг маань бидний сэтгэл зvрхэнд vргэлж итгэл vнэмшил торvүлж, цасны барсууд бидэнтэй vргэлж

хамтдаа тайван амьдрах болно хэмээн тэр бас үгүүлсэн юм.

Энэ удаагийн их наадмын баатруудаар цасны барсаас гадна Алтайн аргаль хонь, начин, шонхор шувуу зэрэг амьтад, цармын арц хийгээд усны самар зэрэг ховор ургамалууд тодорсон.

Монголоос ирсэн зочид маань энэ арга хэмжээнд Алтайн нурууны тусгай хамгаалалтай газрын хамгааллалтын захиргааны дарга Атай Аятхан, Ховд аймаг дахь Дэлхийн байгаль хамгаалах сангийн Алтай - Саяны бүсийн салбарын ажилтан Лхагвасүрэнгийн Алтанцэцэг нараар ахлуулан оролцлоо.

Түүнчилэн энэ үеэр АБНУ-ын “Сайлюгемск”-ийн үндэсний хүрээлэн /парк/-ын захиргаа, Зона покая Укок” буюу “Амар тайван бүс нутаг” байгаль газар зүйн хүрээлэнгүүд ирвэс болон ховор, ховордсон амьтан, ургамлыг хамгаалах чиглэлээр хамтран ажиллах санамжид гарын үсэг зурав.

Кош-Агачийн районд 2010 онд эхэлж байсан санаачлага одоо “Цасны барс” нэртэй, оргон цар хүрээг хамарсан олон улсын арга хэмжээ болж, түүнд хорш Монгол улсын маань өсвөр үе, хүүхдүүд ирж, тун ч идэвх зүтгэлтэй оролцсонд зохион байгуулагчид болон бид бүхэн баяртай байлаа.



ВНУ.